



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/15

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын эрүүл мэндийн төвүүдээс АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны сургуульд төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй сувилагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Төлбөрт шаардагдах 1,456,000 (нэг сая дөрвөн зуун тавин зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/2 дугаар
захирамжийн дөрөвдүгээр хавсралт

**СУМДЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ
БҮРЭЛДЭХҮҮН**

маршрут, үзлэг явуулах хугацаа
1 дүгээр чиглэл

№	Сум багийн нэр	Хугацаа	Хоорондын зай км	Аймгаас ажиллах бүрэлдэхүүн
1	Гуулин тосгон	2023.05.01	90	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-1, техникч-1, бүртгэлийн мэргэжилтэн -1
2	Дэлгэр сум	2023.05.02-04	30	
3	Чандмань сум	2023.05.05-07	150	
4	Эрдэнэ сум	2023.05.08-10	35	
5	Гэгээт баг	2023.05.11	45	
6	Баянтоорой тосгон	2023.05.12	170	
7	Зам хоног	2023.05.13	0	
8	Цогт сум	2023.05.14-16	90	
9	Бигэр сум	2023.05.17-19	87	
10	Алтай хотод ирэх	2023.05.20	110	

2 дугаар чиглэл

1	Олонбулаг баг	2023.05.22	85	Автотээврийн төвийн үзлэгийн инженер-1, техникч-1, бүртгэлийн мэргэжилтэн-1
2	Халиун сум	2023.05.23-24	50	
3	Цээл сум	2023.05.25-27	85	
4	Дэрстэй баг	2023.05.28	45	
5	Алтай сум	2023.05.29-06.01	200	
6	Зам хоног	2023.06.02	0	
7	Тахийн тал	2023.06.03	280	
8	Бугат сум	2023.06.04-06	30	
9	Төгрөг сум	2023.06.07-09	60	
10	Алтай хотод ирэх	2023.06.10	146	

3 дугаар чиглэл

1	Шарга сум	2023.06.12-13	85	Автотээврийн төвийн үзлэгийн инженер -1, техникч -1, бүртгэлийн мэргэжилтэн -1
2	Тонхил сум	2023.06.14-16	125	
3	Дарив	2023.06.17-19	38	
4	Хөх-морьт сум	2023.06.20-21	110	
5	Баян-Уул сум	2023.06.22-24		
6	Зам хоног	2023.06.25	78	
7	Жаргалан сум	2023.06.26-28	75	
8	Тайшир сум	2023.06.29-30	78	
9	Алтай хотод ирэх	2023.06.31	45	

4 дүгээр чиглэл

1	Хан-Алтай ХХК	2023.01 сард	90км	Жагсаалтаар	Автотээврийн төвийн үзлэгийн инженер, техникч, бүртгэлийн мэргэжилтэн
2	Алтайн хүдэр Таян нуурын уурхай	2023.09.12	220км	440	